УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЖОЛООДОХ ЭРХИЙН ОНОО БА ЖОЛООЧИЙН ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН ОНООНЫ СИСТЕМ, ДАВУУ БА СУЛ ТАЛУУД

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/214

ЗАХИАЛАГЧ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.АМГАЛАНБААТАР

Хянасан: ПСХХ-ийн Захирал Д.Бумдарь (Ph.D)

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн хэлтсийн дарга Ц.Норовдондог (Ph.D)

Судалгааг нэгтгэсэн: ПСХХ-ийн ахлах референт И.Жаргалзаяабямба

Судлаачид:

И.Жаргалзаяабямба
Э.Дашзэгвэ
Ц.Ариунаа
Б.Оюунчимэг

Улаанбаатар хот, 2024

ГАРЧИГ

УДИРТГАЛ 4

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ 5

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ 8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЖОЛООДОХ ЭРХИЙН ОНОО, ЖОЛООЧИЙН ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН ТАЛААР ОЛОН УЛСЫН ЖИШИГ 8

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА 17

2.1 АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС 17

2.2. ИБУИНХУ 20

2.3 ХОНКОНГ 22

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын жолоочийн зөрчлийн оноотой холбоотой зохицуулалт, жолоодох эрхийг хасах, зөрчлийн онооны хязгаарын харьцуулалт 6

Хүснэгт 2. Ирландын нийтлэг зөрчил ба тэдгээрийн оноо, торгуулийн хэмжээ.....……15

Хүснэгт 3.Хонконгийн нийтлэг зөрчил ба тэдгээрийн оноо.....17

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ШӨВ	Шинэ Өмнөд Вэльс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ЕХ	Европын Холбоо

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас ирүүлсэн захиалгын дагуу “Гадаадын зарим орны жолоодох эрхийн оноо ба жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны систем, давуу ба сул талууд” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Жолоодох эрхийн оноо ба жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны системийн талаарх олон улсын нийтлэг жишиг, энэхүү системийг нэвтрүүлсэн зарим орнуудын туршлага, давуу болон сул талуудыг гадаадын зарим орны эрх зүйн орчин, туршлагын хүрээнд харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд уг асуудлаарх олон улсын байгууллагуудаас гаргасан судалгааны тайлан, үр дүн болон энэхүү системийг нэвтрүүлсэн Австралийн Холбооны Улс, Хонконг, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс зэрэг орнуудыг сонгон авч хамруулсан бөгөөд сэдвийн хүрээнд дараах асуудлуудын талаар мэдээлэл бэлтгэсэн судалсан болно. Үүнд:

- Зохицуулалтын эрх зүйн орчин;
- Зөрчлийн онооны хязгаар;
- Жолоочийн зөрчил ба тэдгээрийн онооны систем;
- Жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны систем, түүний давуу болон сул талууд.

Судалгааны тайлангийн бүтэц: Судалгааны *Нэгдүгээр бүлэгт*, жолоодох эрхийн оноо ба жолоочийн зөрчлийн бүртгэлийн системтэй холбоотой Европын Холбоонд мөрдөгдөж буй зохицуулалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар; *Хоёрдугаар бүлэгт,* гадаадын зарим орны жолоодох эрхийн оноо ба жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны систем, түүний давуу болон сул талуудын талаарх мэдээллийг Австрали, Их Британи, Хонконгийн туршлага дээр тулгуурлан дэлгэрүүлэн судалсан болно.

Судалгааны арга зүй: Судалгаанд баримт бичиг, мэдээллийн дүн шинжилгээ, захиалга болон удирдамжид заасан чиглэлийн дагуу мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Keywords: *driving license points and driver penalty point, demerit point, advantages and disadvantages*
Түлхүүр үг: *жолоодох эрхийн оноо ба жолоочийн зөрчлийн оноо, торгуулийн оноо, давуу болон сул тал*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Дэлхийн аль ч оронд жолоодох эрх олгох, замын хөдөлгөөний зөрчлийн оноог бүртгэх, зөрчилд хариуцлага тооцох системийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү тогтолцоо нь улс орон бүрд харилцан адилгүй байна. Жолоочийн зөрчлийн онооны систем (*Driving-demerit points System*)-ийн хүрээнд жолооны үнэмлэх олгох *(Drivers license*), жолоочийн зөрчлийн оноо тооцох (*Driving-demerit points*) жолоодох эрхийг хасах *(Disqualification from driving)* зэрэг асуудлуудыг цогцоор нь авч үздэг. Өөрөөр хэлбэл, жолоочийн тодорхой хугацаанд гаргасан зөрчлийн тоог харгалзан торгуулийн оноо (*penalty point)* тооцох, тухайн иргэний жолоодох эрхийг хасах, түдгэлзүүлэх арга хэмжээ авах нь зөрчлийн онооны *(demerit point)* систем юм.

Жолоочийн зөрчлийн онооны бүртгэлийн системийг ашигладаг улс орнуудад замын цагдаа буюу жолоодох эрх олгодог захиргааны байгууллага нь жолоочийн хурд хэтрүүлэх, гэрлэн дохио зөрчих гэх мэт замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдол тус бүр дээр оноо өгч, зөрчлийн онооны нийт дүнгээр оноог тооцох бүртгэл хөтөлдөг.

Жолоочийн зөрчлийн нийлбэр оноо нь тогтоосон босго онооноос хэтэрсэн тохиолдолд торгууль ногдуулах, жолооны сургалтад хамруулж дахин шалгалт өгүүлэх, жолоодох эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх арга хэмжээнүүдийг авдаг байна. Хэрэв замын хөдөлгөөний ноцтой зөрчил гаргасан, хуулийн байгууллагаас гэм буруутай нь тогтоогдсон бол онооны системээр зохицуулахгүйгээр жолоодох эрхийг шууд хасах ба хорих хүртэл шийтгэл ногдуулдаг байна.

Дэлхийн улс орнуудад замын хөдөлгөөний зөрчилд: хурд хэтрүүлэх, гэрлэн дохио зөрчих, согтууруулах болон мансууруулах ундаа хэрэглэсэн үед жолоо барих, эгнээ, байр буруу эзлэх, дохио өгөхгүй эргэх, хамгаалалтын бүс хэрэглэхгүй зорчих, гар утас ашиглах, замын тэмдэг зөрчих, хориотой газар явах, даатгалгүй жолоодох зэрэг нийтлэг зөрчлийг оноонд хамруулдаг бөгөөд тухайн улс орны хууль тогтоомжуудаас шалтгаалан ногдуулах оноо, зөрчлийн бүртгэлийн хугацаа нь өөр өөр байдаг.

Тухайлбал, АНУ, ИБУИНХУ, Австрали, Канад, Герман, Канад, Япон, Швед, Өмнөд Африк, Шинэ Зеланд, Нидерланд, Норвег, Бразил зэрэг улсуудын хувьд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тухай бүрд жолоочийн зөрчлийн оноог нэмж өгдөг системтэй байна. Зөрчлийн онооны тогтоосон босго хэмжээ хэтэрсэн тохиолдолд жолоодох эрхийг хасах буюу түдгэлзүүлдэг байна.

Франц, Испани Улсуудын хувьд жолоочийн зөрчлийн оноог өндөр онооноос эхэлдэг онооны системтэй байна. Зөрчил гаргасан тохиолдолд оноо хасагдах бөгөөд бүх оноогоо алдсан үед жолоодох эрхийг түдгэлзүүлдэг байна. Итали Улсын хувьд зөрчлийн 20 онооноос эхэлдэг бөгөөд онооны дээд хязгаар нь 30 оноо хүрдэгээрээ онцлог байна. (*дэлгэрэнгүйг харна уу)*

ЕХ нь жолооны эрхтэй холбоотой удирдамж боловсруулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, гишүүн улсаас нэгээс нөгөө рүү чөлөөтэй нэвтрэх боломжийг бүрдүүлэх, 250 сая гаруй жолоочийг хамруулан шинэ жолооны үнэмлэхийн загварыг 2033 оноос нэвтрүүлэхээр санал дэвшүүлэн тавьсан.

ЕХ-ны жолооны үнэмлэх буюу жолоодох эрхтэй холбоотой зохицуулалтыг энэхүү удирдамжийн зохицуулсан тохиолдолд улс орнууд харилцан хүлээн зөвшөөрөх үүрэгтэй байдаг.

ЕХ нь 2018 оноос “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратеги үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ стратеги төлөвлөгөөнд 2050 он гэхэд “Зам тээврийн ослыг тэглэх” алсын хараатай шинэ зорилтыг дэвшүүлсэн байна. Ингэснээр, зам тээврийн осол болон бэртэл гэмтлийг 50 хувиар бууруулна гэж ЕХ дурджээ.

Сэдвийн хүрээнд Австрали, Их Британи, Хонконг зэрэг орнуудын жолоочийн зөрчлийн онооны системийг эрх зүйн зохицуулалтын хүрээнд нь судалсан бөгөөд зөрчлийн онооны хязгаар, бүртгэлийн онооны давуу болон сул тал зэрэг мэдээллүүдийг олдсон эх сурвалжийн хүрээнд авч үзсэн болно.

Хүснэгт 1.Судалгаанд авагдсан орнуудын жолоочийн зөрчлийн онооны эрх зүйн орчин, жолоодох эрхийг хасах зөрчлийн онооны хязгаар ба хугацааны харьцуулалт

Улс орнууд	Холбогдох хууль	Жолоодох эрхийг хасах			
		Хугацаа	Зөрчлийн онооны дээд хязгаар	Зөрчлийн онооны доод хязгаар	Эрх хасах хугацаа
Австралийн NSW муж	Зам тээврийн тухай хууль	3 жил	13	0	40 сар
	Зам тээврийн (Жолоодох эрх олгох) журам				
ИБУИНХУ Ирланд	Замын хөдөлгөөний тухай хууль	3 жил	12	0	6 сар
	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль				
	Замын хөдөлгөөний зөрчлийн тухай хууль				
Хонконг	Замын хөдөлгөөний тухай хууль	2 жил	15 ба түүнээс дээш оноо	0	анх 3 сар, давтан 6 сар
	Замын хөдөлгөөний дүрэм				
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль				

Австралийн Шинэ Өмнөд Вэльс (NSW) мужийн хувьд: Жолоодох эрхийг хасах зөрчлийн онооны дээд хязгаар нь 3 жилийн хугацаанд 13 оноо байхаар тогтоосон бөгөөд тухайн жолоочийн эзэмшиж байгаа жолоодох эрхийн төрлөөс хамаардаг байна. Харин торгууль ногдуулах онооны хязгаар нь ямар зөрчил гаргасан зөрчлийн төрлөөс шалтгаалан 1-8 оноо байхаар зохицуулсан. Нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд, мөн сургуулийн орчимд жолооч зөрчил гаргасан тохиолдолд зөрчлийн оноог 2 дахин нэмж ногдуулдаг.

Австралийн зөрчлийн онооны давуу тал[1] нь: замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор зөрчлийг таслан зогсоох, сануулах, арилгах, урьдчилан сэргийлэх, хариуцлагатай жолоочийг дэмжих, шийтгэлийг тодорхой ил тод байлгах, онооны системийн сөрөг үр дагаврыг арилгуулах, жолооч нарт үүргээ ухамсарлах, алдаагаа засах, сайжрах боломжийг олгодгоороо давуу талтай. Харин муж бүрийн онооны хуваарилалт, торгуулийн хэмжээ ялгаатай байдаг нь жолооч нарын хувьд ойлгомжгүй байдаг, суралцагч болон түр

[1] https://roadsense.org.au/complete-guide-demerit-points-in-nsw/

жолооч нарт хатуу шийтгэл оногдуулдаг, захиргааны хүнд суртал, дарамт ихтэй, эдийн засгийн үр дагавар нь харилцан адилгүй зэрэг *сул талтай* гэж үздэг байна.[2]

ИБУИНХУ-ын Ирланд Улсын хувьд: Жолоодох эрхийг хасах зөрчлийн онооны дээд хязгаар нь 3 жилийн хугацаанд 12 оноо ба жолоодох эрхийг 6 сарын хугацаагаар хасдаг байна. Жолоодох эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь гэмт хэрэгт тооцогдоно. Түүнчлэн ямар зөрчил гаргаснаас шалтгаалан 1-3 оноогоор торгууль ногдуулдаг. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар мөнгөн торгууль (€ 80-320 фунт) ногдуулдаг байна. Зөрчилтэйд тооцох хугацаа 3 жил байх ба жолоочийн үйлдсэн зөрчлийн хүнд, хөнгөн, нийгмийн хор аюулын шинж чанараас шалтгаалж жолоочоос оноог хасах эсхүл тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхийг шийдвэрлэдэг.

Ирландын зөрчлийн онооны системийн нөлөөгөөр зам тээврийн осол 15-20%-иар буурсан нь давуу талтай[3] бол торгууль ногдуулах 3 үе шатны процесс нь жолооч нарыг эдийн засгийн дарамтад оруулах, амьжиргааны нөхцөлийг нь харгалзаагүй сул талтай гэж үздэг байна.

Хонконгийн хувьд: Жолоочийн эрх хасах зөрчлийн онооны дээд хязгаар нь 2 жилийн хугацаанд 15 ба түүнээс дээш оноо байх ба жолоодох эрхээ анх удаа хасуулж байгаа жолоочийг 3 сараар, давтан үйлдсэн бол 6 сарын хугацаагаар эрх хасдаг байна. Зөрчлийн хөнгөн, дунд, хүнд гэсэн төрлийг харгалзан 3, 5,10 гэсэн онооны ангиллаар торгууль ногдуулдаг. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар мөнгөн торгууль (HKD 320-5000 Хонконг доллар) ногдуулдаг байна.

Хонконгийн зөрчлийн онооны системийн давуу тал: уг системийн нөлөөгөөр замын хөдөлгөөний зөрчил 30%-иар, осолд өртсөн эмчлүүлэгчдийн тоо 50%-иар, ослын шалтгаантай гэмтэл бэртэл 15-20%-иар тус тус буурсан. Мөн жолоочийн ур чадвар сайжирч, замын хөдөлгөөнд хариуцлагатай оролцох боломжийг бүрдүүлсэн нь сайшаалтай байна[4] гэж үзсэн боловч зөрчлийн оноо тооцож эхэлснээс хойш жолооч болон эрх бүхий байгууллагуудын хооронд багагүй зөрчил үүсэж байгаа нь сул тал гэж үзсэн байна[5].

(*Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү*)

[2] *https://migrationobservatory.ox.ac.uk/resources/reports/the-australian-points-based-system-what-is-it-and-what-would-its-impact-be-in-the-uk/*
[3] *https://www.sciencedirect.com/science/article*
[4] *https://www-sciencedirect-com*
[5] *https://www-sciencedirect-com/science/article/abs/pii/S0967070X12000273?_x_tr_sl=en&_x_tr_tl=mn&_x_tr_hl=mn&_x_tr_pto=sc*

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЖОЛООДОХ ЭРХИЙН ОНОО, ЖОЛООЧИЙН ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН ТАЛААР ОЛОН УЛСЫН ЖИШИГ

Дэлхийн улс орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудал нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Дэлхийн олон улсад замын хөдөлгөөний зөрчлийн оноог бүртгэх, зөрчилд хариуцлага тооцох систем байдаг ба энэхүү тогтолцоо, зохицуулалтын журам нь улс орнуудад харилцан адилгүй байна.

Европын парламентаас 2023 онд дэвшүүлсэн “Жолооны эрхийн удирдамж”[6]-д жолооны эрх ба түүнд хамаарах асуудлуудыг дараах байдлаар тодорхойлсон байна.

Жолооны үнэмлэх *(Drivers license*) гэдэг нь: хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг баталгаажуулсан, эзэмшигчийн жолоодох эрхийн нөхцөл, шаардлагыг илэрхийлсэн цахим болон биет баримт бичгийг хэлнэ.

Жолоочийн зөрчлийн оноо (*Driving-demerit points*) гэдэг нь тодорхой төрлийн зөрчилд эрх бүхий байгууллагаас ногдуулж буй торгуулийн оноог хэлнэ. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар мөнгөн торгууль ногдуулах тохиолдол байна. Зөрчлийн оноо тооцох нь замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх, аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослыг бууруулах зорилготой.

Жолоочийн зөрчлийн онооны систем (*Driving-demerit points System*) гэдэг нь замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд тодорхой хугацаанд хуримтлуулсан зөрчлийн онооны нийлбэрээр тухайн жолоочийн жолоодох эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, торгууль ногдуулах болон хохирол барагдуулах оноог тооцдог хариуцлагын системийн тогтолцоог хэлнэ.

Жолоодох эрхийг хасах *(Disqualification from driving)* гэдэг[7] нь: автомашин барих эрхийг хасах, хүчингүй болгох, хязгаарлах, түдгэлзүүлэх, цаашид давж заалдах эрхгүй болгосон шийдвэрийг хэлнэ.

Жолооны үнэмлэх олгохдоо жолоодох эрхийг тээврийн хэрэгслийн төрлөөр ангилж олгох ба тухайн тээврийн хэрэгслийн техникийн шинж чанар, жолоодох мэдлэг, ур чадварыг тодорхойлсон жолооны шалгалтын дүнг үндэслэж, тээврийн хэрэгслийг жолоодоход бие бялдар, оюун санааны байдал нь нийцэж байгаа эсэхийг харгалзан үздэг байна.

Олон улсад тодорхой хугацаанд хуримтлуулсан зөрчлийн онооны тоогоор тухайн хүний жолооны үнэмлэхийг хасдаг, түдгэлзүүлдэг **торгуулийн оноо** (*penalty point)* болон **зөрчлийн онооны** *(demerit point)* системийг нэвтрүүлсэн байдаг. Замын хөдөлгөөний зөрчил гаргасан тохиолдол бүрд жолоочид зөрчлийн оноо өгдөг ба улс орон, бүс, муж тус бүрд зөрчлийн төрөл хэлбэр, торгууль ногдуулах оноо, ногдуулах шийтгэлүүд нь өөр өөр байдаг байна.

Жолоочийн зөрчлийн онооны системийг ашигладаг улс орнуудад замын цагдаа буюу жолоодох эрх олгох байгууллагын зүгээс жолооч хурд хэтрүүлэх, гэрлэн дохио зөрчих гэх мэт

[6] *https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0127*
[7] *ЕХ-ны удирдамж https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0127*

замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн зөрчил тус бүр дээр оноо тооцож, зөрчлийн онооны нийт дүнг бүртгэх бүртгэл хөтөлдөг.

Жолоочийн зөрчлийн нийлбэр оноо нь тогтоосон босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд нэмэлт торгууль ногдуулах болон жолооны сургалтад хамруулах, дахин жолооны шалгалт өгөх, жолоодох эрхээ хасуулах, жолоодох эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авдаг. Нэмэлт шийтгэлийг тодорхойлон босго оноо нь жолоочийн туршлага, ур чадварын түвшин, өмнө нь гаргасан зөрчил, нас, боловсролын түвшин, бусад хүчин зүйлээс хамаарч өөр өөр байж болно.

Дэлхийн зарим, улс орнуудад жолооч замын хөдөлгөөний ноцтой зөрчил гаргасан (*мөргөх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох*) шүүхээр буруутай гэж тогтоогдсон тохиолдолд онооны системээр зохицуулахгүйгээр жолоодох эрхийг шууд хасах бөгөөд хорих хүртэл шийтгэл ногдуулдаг байна.

Зөрчлийн оноо

Дэлхийн улс орнуудад замын хөдөлгөөний зөрчилд: хурд хэтрүүлэх, гэрлэн дохио зөрчих, согтууруулах болон мансууруулах ундаа хэрэглэсэн үед жолоо барих, эгнээ, байр буруу эзлэх, дохио өгөхгүй эргэх, хамгаалалтын бүс хэрэглэхгүй зорчих, гар утас ашиглах, замын тэмдэг зөрчих, хориотой газар явах, даатгалгүй жолоодох зэрэг нийтлэг зөрчлийг оноонд хамруулдаг бөгөөд тухайн улс орны хууль тогтоомжуудаас шалтгаалан ногдуулах оноо, зөрчлийн бүртгэлийн хугацаа нь өөр өөр байдаг. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, давтан зөрчил гаргаснаас шалтгаалан сургалтад суулгах, эсхүл даатгалын төлбөр өндөр байх зэрэг нэмэлт арга хэмжээнүүд нь ч өөр өөр байна.

Уг системийн гол зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, авар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор жолооч нарыг замын хөдөлгөөний дүрмийг чанд сахин мөрдөхийг хэвшүүлэхэд чиглэгдэнэ.

Жолоочийн зөрчлийн онооны системийг хэрэглэдэг улс орнуудын туршлагыг дараах байдлаар тоймлон дурдсан байна. Тухайлбал[8]:

АНУ-ын хувьд: муж бүр жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тухай бүрд оноо өгдөг онооны системтэй байдаг. Тодорхой хугацаанд хэдэн оноо авахаас шалтгаалан жолоодох эрхийг түдгэлзүүлж, торгууль ногдуулдаг байна.

ИБУИНХУ-ын хувьд: жолооч нар замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн бол оноо өгдөг системтэй. Гурван жилийн хугацаанд нийт 12 оноо авсан жолоочийн жолоодох эрхийг хасдаг. Шинэ жолоочийн хувьд шалгалтад тэнцсэнээс хойш 2 жилийн хугацаанд 6 оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг хасна[9].

Австралийн Холбооны Улсын хувьд: муж, нутаг дэвсгэрүүд тус бүртээ өөр өөр онооны системтэй байдаг. Жишээлбэл, Шинэ Өмнөд Вэльст жолооч нар 3 жилийн хугацаанд 13 оноонд хүрсэн тохиолдолд жолоодох эрхийг хасдаг.

[8] https://poe.com/chat/3myrh0gznudgsd68pd3
[9] https://poe.com/chat/3myrh0gznudgsd68pd3

Канад Улсын хувьд: мужуудад зөрчлийн онооны системийг ашигладаг. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оноо өгдөг бөгөөд өндөр оноо авсан үед торгууль ногдуулах, эсхүл жолоодох эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авдаг. Жишээ нь: Онтариа мужид 15 оноо хүрсэн тохиолдолд жолооны эрхийг түдгэлзүүлдэг бөгөөд нэмэлт шийтгэл нь торгууль ногдуулах, жолооны курст дахин суралцуулах арга хэмжээ авдаг.

Герман Улсын хувьд: "Фленсбургийн онооны систем" гэж нэрлэгддэг онооны системтэй. Замын хөдөлгөөний зөрчил гаргасан тохиолдолд оноо өгдөг бөгөөд жолооч нар өндөр оноо авсан тохиолдолд торгууль ногдуулдаг.

Франц Улсын хувьд: жолооч нар 12 онооноос эхлэх онооны системийг ашигладаг. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оноо хасагдах бөгөөд бүх оноогоо алдсан тохиолдолд жолоодох эрхийг нь хасдаг байна. Жолооч нар аюул, осолгүй жолоодох буюу сургалтад дахин хамрагдсанаар оноогоо эргүүлэн авах боломж бүрддэг.

Итали Улсын хувьд: зөрчлийн 20 оноогоор эхэлдэг онооны системтэй. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оноо хасагдах ба тэг оноонд хүрэх үед жолоодох эрхийг түдгэлзүүлэхэд хүргэдэг.

Испани Улсын хувьд: шинэ жолоочийн хувьд 8 оноо, бусад жолооч нар 12 онооноос эхэлдэг онооны системтэй. Зөрчил гаргасан тохиолдолд оноо хасагдах бөгөөд бүх оноогоо алдсан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлнэ.

Япон Улсын хувьд: жолооч нар замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оноо авах онооны системтэй. 3 жилийн хугацаанд 6 оноонд хүрсэн тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлдэг. Замын хөдөлгөөний ноцтой гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шууд жолоодох эрхийг хасан буюу хүнд шийтгэл ногдуулдаг байна.

Швед Улсын хувьд: замын хөдөлгөөний зөрчилд оноо өгдөг хохирлын онооны системийг ашигладаг. Хэт их өндөр оноо авах нь торгууль болон жолоодох эрхийг хүчингүй болгоход хүргэдэг. Жолоочийг давтан сургах сургалтад хамруулдаг байна.

Өмнөд Африк Улсын хувьд: жолооч нар замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тохиолдолд оноо авдаг онооны системтэй. 12 оноо авсан тохиолдолд жолоочийн жолоодох эрхийг 3-6 сарын хугацаанд түдгэлзүүлнэ. Дахин давтан дүрэм зөрчсөн тохиолдолд удаан хугацаагаар жолоодох эрхийг түдгэлзэхэд хүргэдэг.

Шинэ Зеланд Улсын хувьд: зам хөдөлгөөний дүрэм зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд оноо өгдөг онооны системтэй. 2 жилийн хугацаанд 100 оноо буюу хэт их өндөр оноо авсан үед жолоодох эрхийг түдгэлзүүлдэг. Жолоочид торгууль ногдуулж, нэмэлт сургалтад хамруулах боломж бүрддэг.

Нидерланд Улсын хувьд: замын хөдөлгөөний дүрэм зөрчиж хэт их өндөр оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлдэг. Оноо нь торгууль ногдуулах, давтан гэмт хэрэг үйлдсэн жолоочид нэмэлт сургалт явуулах боломжтой байна.

Дэлхийн зарим орнуудын жолоочийн зөрчлийн онооны системийн онцлогийг тоймлон авч үзвэл:[10]

[10] *Point system (driving)* https://en.wikipedia.org/wiki/Point_system_(driving)

Австралийн Холбооны Улсын хувьд: Муж, нутаг дэвсгэрийн засгийн газрууд нь замын хөдөлгөөний зөрчлийн онооны системийг баталдаг байна. Шинэ Өмнөд Вэльс мужид гурван жилийн хугацаанд 13 оноо авахыг хүлээн зөвшөөрдөг бол бусад мужуудад гурван жилийн хугацаанд 12 ба түүнээс дээш оноо авсан жолоочийн жолоодох эрхийг шууд хасдаг байна. Жолоодох эрхийн хугацааг гурван сараар хасдаг бол босго онооноос давсан дөрвөн оноо тутамд нэг сараар нэмэгдүүлдэг ба ихэнх мужид эрхийг таван сараар түдгэлзүүлдэг байна.

Шинэ Өмнөд Вэльс мужид: жолоочийн түр үнэмлэх эзэмшигчийн эрхийг жолоодох эрхийн төрлөөс хамааран:

- 12-18 сарын хугацаанд P1 түр үнэмлэх эзэмшигчид 4 оноо;
- 24-30 сарын хугацаанд P2 түр үнэмлэх эзэмшигчд 7 оноог гурван сарын хугацаагаар түдгэлзүүлдэг байна.

Харин хурд хэтрүүлсэн, хамгаалах бүс хэрэглээгүй, согтууруулах ундаа болон мансуурах бодис хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодсон, 30 км цагаас дээш хурд хэтрүүлсэн, зөрчил гаргасан этгээдэд давхар шийтгэл ногдуулдаг байна.

Викториа мужийн хувьд: 2020 оноос эхлэн 45 км цаг түүнээс дээш хурд хэтрүүлсэн, гэмт хэрэг үйлдэж, зэвсэг ашигласан, хүний эрүүл мэндийг ноцтой хохироосон тохиолдолд жолоодох эрхийг нэн даруй түдгэлзүүлэх хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Өмнөд Австрали Улсын хувьд: нийт гурван жилийн хугацаанд 12 оноо ба түүнээс дээш оноо авсан жолоочийн жолоодох эрхийг хасдаг байна. Үүнд:

- 12-15 оноо авсан тохиолдолд 3 сар хугацаагаар;
- 16-20 оноо авсан тохиолдолд 4 сарын хугацаагаар;
- 20 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд 5 сарын хугацаагаар жолоодох эрхээ хасуулдаг байна.

Дани Улсын хувьд: замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочийн зөрчлийг бүртгэдэг торгуулийн онооны системтэй. Жолооны түр үнэмлэхтэй жолооч 3 удаа торгуулийн оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлдэг байна. Жолоодох эрхээ хасуулсан жолооч жолооны дадлага болон бичгийн шалгалт өгнө. Хэрэв жолооч торгуулийн оноо аваагүй, зөрчил гаргаагүй тохиолдолд жолоочид урамшууллын 3 оноо хасаж, гурван жилийн дараа замын цагдаагийн цахим мэдээллийн сангаас хасдаг байна.

ИБУИНХУ-ын Англи, Вэльс Улсын хувьд: 1988 оны Замын хөдөлгөөний зөрчлийн тухай хуульд заасны дагуу замын хөдөлгөөний гэмт хэрэгт шүүхээс торгуулийн оноо өгдөг байна. Оноо өгсөн гэмт хэргийн 3 оноо, хамгийн хүнд гэмт хэрэгт 11 оноо, ослын улмаас олон зөрчил гаргасан, нэг зөрчлийг олон удаа үйлдсэн, ихэнх хэрэгт 3 ба түүнээс дээш торгуулийн оноо авдаг байна. Жолоочийн зөрчлийн оноо бүртгэгдсэнээс хойш 4 жилийн хугацаанд архи, мансуурах бодис хэрэглэсэн бол 11 жилээр, 3 жилийн дотор 12 оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг хасдаг байна. 1995 оны Замын хөдөлгөөний тухай хуулийн шинэчлэлтээр жолооч 2 жилийн хугацаанд 6 оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг цуцалж, дахин өргөдөл гаргаж, төлбөр төлж, шалгалт өгдөг.

Хойд Ирланд Улсын хувьд: жолоочийн зөрчлийн онооны систем нь Их Британийнхаас тусдаа бөгөөд торгуулийн оноо, зөрчлүүд өөр өөр хуультай байдаг. Бусад талаараа Англи, Вэльсхийхтэй төстэй.

Шотланд Улсын хувьд: тусдаа харьяалалтай. Жолоочийн зөрчлийн онооны систем нь Их Британийнхтай адил бөгөөд 1988 оны Замын хөдөлгөөний зөрчлийн тухай хуулиар зөрчлийн онооны системийг зохицуулж байна.

Герман Улсын хувьд: Холбооны Авто тээврийн газар нь замын хөдөлгөөний зөрчлийн 8 онооны системийг хэрэгжүүлдэг. Энэ зөрчлийг системийг 2014 оноос нэвтрүүлсэн бөгөөд замын хөдөлгөөнтэй холбоотой гэмт хэргийн төрөл, хүнд, хөнгөнөөс шалтгаалан 2.5-10 жилийн дараа жолоодох эрхийг түдгэлзүүлдэг байна. Тодорхой нөхцөлд 8 ба түүнээс дээш оноо авсан этгээдийн жолоодох эрхийг хүчингүй болгодог. Жолоодох эрхийг хүчингүй болгосон тохиолдолд эмнэлгийн болон сэтгэл зүйн дүгнэлт гаргасны дараа жолооны эрхийг сэргээдэг байна.

Ирланд Улсын хувьд: жолоодох эрхийг зургаан сарын хугацаатайгаар хасах бөгөөд нийт зөрчлийн дээд хязгаарын оноо нь 12 хүрсэн байна. Жолооч нарын замын хөдөлгөөнд гаргасан нийт 38 зөрчлийг шуудангаар ирүүлэх бөгөөд 1-2 онооны торгуулийг ногдуулдаг. Хэрэв замын хөдөлгөөний ноцтой 10 зөрчлийн гэмт хэрэг бүртгэгдсэн тохиолдолд 3-5 онооны торгууль ногдуулж, шүүхээр заавал шийдвэрлүүлдэг байна. Мөн ноцтой гэмт хэрэг нь шүүхээр батлагдсан бол жолоодох эрхийг автоматаар хасах, зарим тохиолдолд хорих арга хэмжээг ч хүртэл авдаг байна.

Итали Улсын хувьд: жолоодох эрхийг авснаас хойш 2 жилийн хугацаанд 20 оноогоос эхэлнэ. Онооны дээд хязгаар нь 30 оноо байна. Замын хөдөлгөөний дүрэм, гэрлэн дохио зөрчсөн гэх мэт гаргасан зөрчил бүрд 6 онооны торгуулийг ногдуулдаг. Жолооч жилийн бүх оноогоо хасуулсан тохиолдолд мөн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үед жолоодох эрхийг хасах бөгөөд мэдэгдлийг биечлэн гардуулж өгснөөс хойш хүчинтэй хугацаа үйлчилнэ. Жолоодох эрхийг хасах мэдэгдлийг гардуулж өгсөн хүнд жолооны үнэмлэхээ хураалгах эрхтэй байдаг.

Нидерланд Улсын хувьд: 2002 оноос жолоочийн зөрчлийн онооны системийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд жолооны шалгалтад тэнцсэнээс хойш 5 жил, 18 нас хүрэхээс өмнө тэнцсэн бол 7 жилийн хугацаанд бүртгэдэг байна. Жолооч 5 жилийн дотор 2 оноо авсан тохиолдолд жолоодох эрхээ хасуулж, дахин жолооны шалгалт өгөх эрх үүснэ. 2014 онд Замын хөдөлгөөний дүрэмд өөрчлөлт оруулж, зөрчлийн дээд хязгаар 3 оноо байсныг 2 оноо болгон бууруулсан байна. Жолооч нар замын хөдөлгөөний дараах зөрчилд оноо авдаг байна. Үүнд:

- замын хөдөлгөөнд аюул учруулсан бол;
- амь насаа алдах, осол, бэртэл гэмтэл учруулсан бол;
- ачаа тээвэрлэлтэд саад учруулсан бол;
- хурдны хязгаар 40 км цагаас дээш (хурдны зам) эсхүл 30 км/цаг (бүх зам) байсан бол;
- хохирол учруулсан, хууль зөрчсөн үйлдэл зэрэг болно.

Жолооч замын хөдөлгөөний зөрчил гаргаж, 2 оноотой авсан тохиолдолд жолоодох эрхийг автоматаар хасаж, дахин жолооны шалгалт өгөх шаардлага үүсдэг. Харин энгийн зөрчил гэж үзсэн тохиолдолд хэдэн сараар жолооны эрхийг нь хасаж болдог.

Норвег Улсын хувьд: замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч нарыг зөрчлийн онооны системээр үнэлдэг. 2011 оноос замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, гэрлэн дохио зөрчсөн тохиолдолд торгуулийн 3 оноогоор торгодог. Замын хөдөлгөөнд жолооч нар 10-15 км цаг, эсхүл 15-20 км цагийн хурдтай тээврийн хэрэгслийг жолоодсон тохиолдолд 2 оноогоор, 18-20 насны залуу жолооч нарт хоёр дахин их оноогоор торгодог байна. Нийт 3 жилийн хугацаанд торгуулийн 8 оноо авсан жолооч нарын жолоодох эрхийг 6 сарын хугацаагаар

хасна. Жолоодох эрхээ 6 сараар хасуулсны дараа жолоодох эрхээ сэргээхэд түдгэлзүүлсэн гэж оноо хасагддаг байна.

Канад Улсын Альберт мужид: жолооч 2 жилийн хугацаанд 15 ба түүнээс дээш зөрчлийн оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг нэг сарын хугацаагаар автоматаар хасдаг байна.

Канадын Онтарио мужид: мөн адил зөрчлийн 15 онооны системийг ашигладаг бөгөөд торгуулсны дараа жолоочийн бүртгэлд оноо “нэмдэг" юм байна. Үүнд: Онтарио мужийн нутаг дэвсгэрт өндөр даацын тээврийн хэрэгслийг жолоодож буй жолоочид 3 оноо өгдөг байна. Бусад мужууд, Нью-Йорк, Мичиган мужуудад зам тээврийн дүрмийн зөрчил гаргасан тохиолдолд Онтарио мужийн зөрчил гаргасантай адил жолооны бүртгэлд оноо нэмэгддэг.

Канадын Нью Брансвик мужид: зөрчлийн 10 онооны системийг ашигладаг бөгөөд жолооч 0 оноо хүрсэн тохиолдолд жолоодох эрхийг хасдаг. Шинэ жолооч нарын хувьд анх 4 онооноос эхэлдэг бөгөөд замын хөдөлгөөний дүрмийг сахин аюулгүй жолоодсон хоёр оноог нэмж, онооны дээд хязгаар 10 оноо хүрдэг байна. Нью-Брансвик мужид жолооч гар утас эсхүл GPS ашиглаж байхдаа анхаарлаа сарниулсан тохиолдолд торгууль ногдуулахаас гадна зөрчлийн 3 оноог хасдаг. Хэрвээ замын хөдөлгөөнд оролцож байхдаа хамгаалалтын бүс зүүгээгүй тохиолдолд торгууль ногдуулахаас гадна зөрчлийн 2 оноог хасна.

АНУ-ын хувьд: зөрчлийн онооны систем муж бүрд өөр өөр байдаг. Автомашин болон жолоочийн эрхтэй холбоотой асуудлуудыг даатгалын компаниудад мэдээлдэг бөгөөд жолоочоос ямар хэмжээний төлбөр авах, даатгалын гэрээг шинэчлэх эсхүл цуцлах эсэхийг тодорхойлоход харгалзан үздэг байна[11].

АНУ-ын Аризона мужид: онооны системийг ашигладаг бөгөөд нэг жилийн дотор 8 оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлдэг. Үүнд: замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдолд дараах зөрчлийн оноог өгдөг байна.

- согтууруулах ундаа (DUI)-ны цусан дахь архины концентраци (BAC)-ийн хэмжээ 0.08% түүнээс дээш байх үед 8 оноо;
- согтууруулах ундаа (DUI)-ны хэмжээ хэт их үед 8 оноо;
- болгоомжгүй жолоодсон бол 8 оноо;
- түрэмгий жолоодсон бол 8 оноо;
- ослын газрыг орхисон үед 6 оноо;
- тэмдэг, гэрлэн дохио зөрчсөн, осолд амь насаа алдсан бол 6 оноо;
- тэмдэг, гэрлэн дохио зөрчсөн, хүнд гэмтэл учруулсан бол 4 оноо;
- хурд хэтрүүлсэн бол 3 оноо;
- замын эгнээ, байр буруу эзлэх, талбайн дээгүүр машин жолоодсон бол 3 оноо;
- бусад бүх төрлийн зөрчил 2 оноо;
- олон нийтийн тээврийн хэрэгслийн эгнээ, байр буруу эзлэх үед 3 оноог тус тус өгдөг байна.

АНУ-ын Калифорний мужид: зөрчлийн онооны дээд хязгаарт хүрсэн жолоочийг хайхрамжгүй хандсан гэж үзэн жолоодох эрхийг хасдаг байна. Замын хөдөлгөөнд оролцож байхдаа мөргөх, болгоомжгүй жолоодох, согтуугаар тээврийн хэрэгсэл барих зэрэг томоохон зөрчлүүдэд 2 оноо өгч, 13 жилийн турш бүртгэлд хөтөлсөн хэвээр байдаг байна. Хүндэвтэр

[11] https://2009-2017.state.gov/ofm/dmv/c66584.htm

зөрчил гаргасан үед 39 сарын хугацаанд 1 оноог өгдөг байна. Жолооч замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдолд дараах зөрчлийн оноог өгч, хайхрамжгүй хандсан гэж үздэг.

- 12 сарын хугацаанд 4 оноо;
- 24 сарын хугацаанд 6 оноо;
- 36 сарын хугацаанд 8 оноо.

Калифорний мужийн шүүгч нар дараах зөрчлийг гаргасан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлнэ.

- хурдны дүрмийг зөрчих эсхүл анхаарал сарнисан үед жолоодсон бол;
- согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед жолоодсон бол;
- байрнаас 300 метр зайд тээврийн хэрэгслээр садар самуун хэрэг үйлдсэн бол;
- хурдны замд дээр дугуй унасан болон явган зорчигчийг гэмтээсэн бол;
- төмөр замын гарам дээр зогсоогүй бол;
- хууль сахиулагчдаас оргон зайлсан, хүнд гэмт хэргийн үед жолоодох эрхийг хасдаг байна.

АНУ-ын Колорадо мужийн хувьд: моторт тээврийн хэрэгслийн зөрчлийн онооны системийг ашигладаг. Замын хөдөлгөөний зөрчил, жолоодох эрхийн онооны системд заасны дагуу шүүх шийдвэрийн тухай Авто тээврийн хэлтэст (DMV) мэдэгдэж, жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноог тодорхой хэмжээнд тооцдог. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон, торгуулийн нийт дүнг шуудангаар илгээсэн эсхүл шүүх хуралд ирж оролцоогүй тохиолдолд ял шийтгэл хүлээлгэдэг. Зөрчлийн оноо нь жолоочийн тээврийн хэрэгслийн бүртгэлд 7 жил хугацаатай хадгалагдан үлддэг. Тээврийн хэрэгслийн зөрчилд 12 оноо авдаг бөгөөд энэ нь жолоодох эрхийг шууд түдгэлзүүлэхэд хүргэдэг. Мөн 12 болон 24 сарын хугацаанд зөрчлийн оноо авсан, замын хөдөлгөөний дүрмийг олон удаа зөрчсөн тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлнэ.

АНУ-ын Флорида мужийн хувьд: Колорадо мужтай төстэй зөрчлийн онооны системийг ашигладаг. Флоридагийн Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэлтэс нь жолоодох эрхийг олгох үүрэгтэй бөгөөд мужийн хэмжээнд жолоодох эрхийн оноог хянадаг байна. Дараах замын хөдөлгөөний дүрмийг зөрчсөн тохиолдолд дараах оноог өгдөг байна. Үүнд:

- хурдны хязгаараас 14 миль ба түүнээс бага үед 3 оноо;
- хурдны хязгаараас 15 миль ба түүнээс дээш үед 4 оноо;
- ослын хэмжээнд хурд хэтрүүлсэн үед 6 оноог ногдуулах бөгөөд олон нийтийн газарт автомашинаар уралдахыг хориглосон байна. Мөн сургуулийн орчин, барилга байгууламжийн бүсэд хурд хэтрүүлэн жолоодсон тохиолдолд торгуулийн оноог хоёр дахин нэмэгдүүлдэг.

Замын хөдөлгөөний дүрмийг дараах хугацаанд зөрчсөн үед жолоодох эрхийг түдгэлзүүлдэг байна. Үүнд:

- 12 сарын хугацаанд 12 оноо авсан бол 30 хоног;
- 18 сарын хугацаанд 18 оноо авсан бол 3 сар;
- 36 сарын хугацаанд 24 оноо авсан бол жолоодох эрхийг 12 сарын хугацаагаар түр хасдаг байна.

Насанд хүрээгүй жолооч 12 сарын хугацаанд 6 ба түүнээс дээш оноо авсан үед жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар автоматаар хязгаарладаг. Замын хөдөлгөөний ердийн (DUI биш) зөрчил гаргасан эсхүл шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлсэн бол жолоодох эрхийг сэргээхээс өмнө эзэмшигч нь жолооны ахисан түвшний сургалтад хамрагдана.

Бразил Улсын хувьд: Замын хөдөлгөөний дүрмийн дагуу тээврийн хэрэгслийг жолоодож буй жолоочийн зөрчлийг ангилан, тодорхой тооны зөрчлийн оноог өгдөг. Жолооч нийт оноо нь 20-оос дээш (түр жолоочийн хувьд 5 оноо) авсан тохиолдолд жолоодох эрхийг түдгэлзүүлдэг байна. Жолоодох эрхийг дахин авахын тулд замын хөдөлгөөний дүрмийн сургалтад хамрагдана. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, гудамж талбай, олон нийтийн газар автомашинаар уралдах зэрэг асуудлыг онооноос үл хамааран жолоодох эрхийг шууд түдгэлзүүлдэг. Дараах тохиолдолд зөрчил гэж тооцон оноо нэмж өгдөг байна. Үүнд:

- замын хөдөлгөөнд оролцож байхдаа гар утас ашигласан тохиолдолд ердийн зөрчил гэж тооцон 3 оноо;
- гарц, уулзвар, зөвшөөрөгдөөгүй зогсоолд зогссон тохиолдолд дунд зэргийн зөрчил гэж тооцон 4 оноо;
- хамгаалалтын бүс зүүгээгүй, эгнээ байр буруу эзлэх, хурд хэтрүүлсэн тохиолдолд хүнд зөрчил гэж тооцон 5 оноо;
- гэрлэн дохио, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлсэн тохиолдолд маш хүнд ноцтой зөрчилд тооцон 7 онооны торгууль өгдөг байна.

Европын Холбоо (ЕХ)-ны зохицуулалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ[12]

“Жолооны эрхийг олгох тухай” Европын Парламентын удирдамж (*Directive of the European Parliament and of the Council on driving licences*) боловсруулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахаар дэвшүүлэн тавьжээ.

Энэ нь (2023/0053 COD) жолооны үнэмлэхийн тухай холбооны дүрэмд томоохон өөрчлөлт оруулахтай холбоотой бөгөөд 1980, 1991, 2006 онуудад нийт 3 удаагийн удирдамжаар шинэчилсэн найруулга юм.

Жолоодох эрхтэй холбоотой дүрэм журам нь тээврийн нийтлэг бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, үнэмлэх олгосон улсаас өөр гишүүн улсад оршин сууж буй иргэдийн чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлдэг.

ЕХ-ны замын хөдөлгөөний аюулгүй байдал сүүлийн 20 жилийн дунджаар сайжирсан үзүүлэлтэй байсан. Тухайлбал, зам тээврийн ослын улмаас нас барсан иргэдийн тоо 2011 онд 51,400 байсан бол 2021 онд 19,800 хүрч, 61.5%-иар буурсан үзүүлэлтэй байсан. Тэгсэн ч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний үр дүн шаардлагатай хэмжээнд хүрч чадаагүй гэж дүгнэсэн[13] байна.

ЕХ-ны Комисс 2018 оноос эхлэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын стратеги үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн. Энэ стратеги төлөвлөгөөнд 2050 он гэхэд ЕХ-ны хэмжээнд зам тээврийн ослыг тэглэх (Vision Zero) алсын хараатай зорилт дэвшүүлж, шинэ аргыг хэрэгжүүлэх, удаан хугацаанд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар болсон байна.

2019 онд ЕХ-ны Комисс нь 2021-2030 онд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бодлогын тогтолцооны тухай” (*EU Road Safety Policy Framework 2021-2030*) сэдвээр Европын Парламентын 2021 оны тогтоолоор “Замын хөдөлгөөний ослыг тэглэх” (*Vision Zero)* алсын

---

[12] *Directive of the European Parliament and of the Council*
https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0127#footnote27

[13] *Directive of the European Parliament and of the Council*
https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0127#footnote27

хараанд чиглэсэн алхам хийж, зам тээврийн осол болон хүнд гэмтэл учруулсан тохиолдолд 50%-иар бууруулахаар шинэ зорилтуудыг дэвшүүлжээ.

ЕХ-ны болон бусад Европын Эдийн засгийн бүс (ЕЕА)-ийн гишүүн орнуудад[14] дэлхийн дэвшилтэт шинэ тогтолцоо, ЕХ-д хүлээн зөвшөөрөгдөх, хууль тогтоомж, нийтлэг арга хэмжээнд нийцүүлэн тогтоосон жолооны үнэмлэхийн удирдамжийг мөрддөг байна. Энэ удирдамжид нийтдээ 250 сая гаруй жолоочийг хамруулсан бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, ЕХ-ны иргэд чөлөөтэй зорчих боломжийг олгох зорилготой юм.

ЕХ нь 2033 оноос эхлэн жолооны үнэмлэхийг хуурамчаар үйлдэхээс урьдчилан сэргийлж, шинэ загварыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- жолооны үнэмлэхийг тээврийн хэрэгслийн төрөл, жолоодох насны доод хязгаараар ангилах;
- шинээр олгосон жолооны үнэмлэхийг 10 жил тутамд холбогдох захиргааны байгууллагаар сунгуулах;
- оршин суугаа газар болон өөр улсад байгаа жолоочийн ачааллыг хөнгөвчлөх;
- жолоочийн ур чадвар, мэдлэг, бие болон оюуны чадамжийг илэрхийлсэн стандартыг хэрэглэх;
- тээврийн хэрэгслийн хүчин чадал багаас эхлэн ихэсгэх бодлого баримтлах;
- үндэсний болон бусад эрх бүхий байгууллагуудтай жолооны үнэмлэхтэй холбоотой мэдээлэл солилцох сүлжээг бий болгох зэрэг асуудлуудыг тодорхойлсон байна.

ЕХ-ны орнуудад тухайн оршин суух газрын замын хөдөлгөөний дүрмүүд өөр өөр байх тохиолдол байна. Жолооны эрхийн үнэмлэхийг тээврийн хэрэгслийн ангиллын дагуу олгодог бөгөөд зарим ангиллыг ЕХ-ны дүрмийн дагуу зохицуулдаг.

Гишүүн орнууд өөр улсаас олгосон жолооны үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байдаг тул нэмэлт дүрмээр чөлөөтэй зорчих боломжийг олгодог байна.

ЕХ-ны замын хөдөлгөөнд оролцогчдод тэгш эрх, ил тод, үр ашигтай, уялдаа холбоотой арга барил, ялангуяа жолооны үнэмлэхийг харилцан хүлээн зөвшөөрөх зарчмыг хэрэгжүүлэх, шаардлагатай нөхцөл бололцоог хангах зэрэг зарчмууд нь ижил тэгш байгаа юм.

Зөвшөөрөл олгосон улсаас өөр гишүүн улсад оршин сууж буй жолооч нар чөлөөтэй зорчиход тулгарч буй саад бэрхшээлийг арилгахын тулд холбогдох захиргааны дүрэм журмуудыг хялбарчлах, цахим систем нэвтрүүлэх явдал чухал гэж үзсэн байна.

ЕХ-ны жолооны үнэмлэх буюу жолоодох эрхтэй холбоотой зохицуулалтыг энэхүү удирдамжийн зохицуулсан тохиолдолд улс орнууд харилцан хүлээн зөвшөөрөх үүрэгтэй байдаг.

[14] *Европын Эдийн засгийн бүс (ЕЕА) орнуудад Исланд, Лихтенштейн, Норвег орно.*

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА

2.1 АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Австралийн Холбооны Улс (Австрали) нь ардчилсан парламент бүхий үндсэн хуульт хаант засаглалтай, холбооны улс юм. Австрали нь Шинэ Өмнөд Вэльс, Квийнслэнд, Өмнөд Австрали, Тасмани, Виктория, Баруун Австрали гэсэн зургаан мужтай бөгөөд Нийслэл хотын бүс, Хойд нутаг гэсэн хоёр тусгай засаг захиргааны нэгжтэй. Тэдгээр муж тус бүр өөрийн гэсэн хууль дүрэм тогтоох байгууллага болон амбан захирагчтай. Хэдийгээр муж тус бүр өөрийн гэсэн хууль, эрүүл мэнд, боловсролын систем, батлан хамгаалах бодлого, эдийн засгийн хараат бус байдалтай ч төрийн байгууллыг сонгох, томилох, улсын хэмжээнд хууль тогтоох эрх[15] мэдлийг гагцхүү холбооны парламент хянаж байдаг.

Австралийн Холбооны Улс нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жолоочийн зан үйл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах, зохицуулах, хянах зорилгоор жолоочийн зөрчлийн онооны адилтгасан систем хэрэглэдэг боловч замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн асуудал мужийн эрх хэмжээнд хамаардаг учраас муж бүр өөр өөрийн хууль дүрмээр нарийвчлан зохицуулдаг. Гэвч тэдгээрийн зохицуулалтын ерөнхий агуулга, зарчим нь улс даяар адил төстэй байдаг. Жолоочийн зөрчлийн онооны систем нь замын хөдөлгөөний зөрчил гаргасан жолооч нарт зөрчил гаргасан даруйд сануулах, шийтгэх замаар тэдэнд аюул, эрсдэлгүй жолоодох дадал, зуршил, ур чадварыг суулгах, хөгжүүлэх зорилготой юм. Австралийн дээр дурдсан мужуудаас “Шинэ Өмнөд Вэльс” (NSW) мужийн жолоочийн зөрчлийн онооны системийг жишээ болгон танилцуулъя.

Эрх зүйн орчин

Шинэ Өмнөд Вэльс мужийн жолоочийн зөрчлийн онооны систем дараах хууль тогтоомжоор зохицуулагддаг. Үүнд:

- Зам тээврийн тухай хууль (*Road Transport Act 2013 (NSW)*[16]. 2013 онд батлагдсан тус хууль нь ШӨВ-ийн зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулдаг үндсэн гол эрх зүйн акт бөгөөд жолоочийн зөрчлийн онооны систем, жолоочийн зөрчлийн оноо, торгууль, замын хөдөлгөөний зөрчлийг хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг тодорхойлсон. Тус хуульд заасан зөрчлийн оноотой холбоотой тусгайлсан зохицуулалтууд гэвэл: замын хөдөлгөөний зөрчлийг тодорхойлох, тухайн зөрчилд оноо тооцох, тусгай зөвшөөрөл буюу жолоодох эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох босго оноо зэргийг тусгасан.
- Зам тээврийн (Жолоодох эрхийн үнэмлэх) журам (*Road Transport (Driver Licensing*) Regulation 2017 (NSW)[17]. 2017 онд батлагдсан тус журам нь ШӨВ мужийн жолоочийн зөрчлийн онооны системийн удирдлага, хэрэгжилт, хяналт, бүртгэлийн талаар нарийвчлан зохицуулсан. Үүнд: эрх бүхий төрийн байгууллагууд зөрчлийн оноог хэрхэн бүртгэх, сан бүрдүүлэх, санг удирдан зохион байгуулах талаар болон зөрчлийн оноог давж заалдах, түр түдгэлзүүлэх тухай мэдэгдэл гаргах үйл явц, түүнчлэн жолоочид нэмэлт боловсрол олгох, нөхөн сэргээх хөтөлбөрт тавигдах шаардлага зэргийг тус тус тодорхойлсон.

Жолоочийн зөрчлийн онооны систем

[15] *Австралийн Холбооны Улсын хууль тогтоомж: https://www.legislation.gov.au/Home*
[16] *https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/act-2013-018*
[17] *https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/sl-2017-0450*

Жолоочийн зөрчлийн оноо гэдэг нь жолоодох эрхийн үнэмлэх бүхий этгээд зам тээврийн тодорхой зөрчил гаргасан тохиолдолд түүнд ногдуулах торгуулийн оноо юм. Бүх жолооч 0 оноотойгоор эхэлнэ. Өөрөөр хэлбэл тухайн жолооч ямар ч аюул, эрсдэл гаргалгүйгээр жолоо барьдаг бөгөөд ямар нэгэн зөрчил гаргаагүй бол түүний оноо 0 байна. Хэрэв жолооч автомашин жолоодож байхдаа буюу эсхүл мотоцикл унаж байхдаа зөрчил гаргасан бол тухайн жолоочийн бүртгэлд зөрчлийн оноо нэмэгдэнэ. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар торгууль ногдуулдаг.

Австралиийн Холбооны Улсын хаана ч зөрчил гаргасан зөрчлийн онооны адилтгасан систем үйлчилнэ. ШӨВ-ийн нутаг дэвсгэрээс гадна гаргасан зөрчилд ч тухайн жолоочийн оноо бүртгэгддэг.

Зөрчлийн онооны хязгаар

Зөрчлийн онооны хязгаар гэдэг нь тухайн жолоочийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох буюу цуцлах, эсхүл сунгуулах хүсэлт гаргахаас татгалзах үндэслэл болгох тухайн жолоочийн хуримтлуулж болох онооны дээд хэмжээ юм. Хэрэв зөрчлийн онооны хязгаарт хүрвэл Авто тээврийн газраас жолоодох эрхийг түдгэлзүүлсэн, цуцалсан тухай, эсхүл жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан бол татгалзсан тухай мэдэгдэл илгээнэ. Тус мэдэгдэлд түдгэлзүүлэх, цуцлах, эсхүл татгалзах хугацаа эхлэх огноог заавал тусгана. Жолоочийн зөрчлийн онооны хязгаар нь тухайн жолоочийн эзэмшиж байгаа жолоодох эрхийн төрлөөс хамаарна. Үүнд[18]:

- ердийн хугацаагүй үнэмлэх 13 оноо;
- мэргэжлийн жолоочийн үнэмлэх 14 оноо;
- түр P2 үнэмлэх 7 оноо;
- түр P1 үнэмлэх 4 оноо;
- суралцагчийн үнэмлэх (L) 4 оноо;
- тэнсэх хугацаанд олгогдсон түр үнэмлэх 2 оноо.

Тухайн жолоочийн гаргасан зөрчил, түүнд оногдуулсан онооны бүртгэл нь мэдээллийн санд байнга хадгалагддаг боловч зөвхөн сүүлийн 3 жил доторх зөрчлийн оноо л жолоодох эрхийг түдгэлзүүлэх болон бусад хариуцлага тооцох үндэслэл болно. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 40 сар байдаг.

Нийтлэг зөрчил ба тэдгээрийн оноо: ШӨВ муж төдийгүй ихэнх муж, орон нутаг зөрчилд оногдуулах онооны хэмжээ ойролцоо байдаг. Нийтлэг зөрчил, тэдгээрт ногдуулах онооныд нь[19]:

- Хурд: хэтрүүлсэн хурдны хэмжээнээс хамаарч 1-8 оноо;
- Жолоо барьж байх үедээ гар утас хэрэглэх: 3-5 оноо;
- Улаан гэрлээр гарах: 3 оноо;
- Хамгаалалтын бүс үл хэрэглэх: 3 оноо.
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох: эрхийг нь нэн даруй цуцалж, торгууль болон хорих шийтгэл оногдуулна.

[18] https://www.nsw.gov.au/driving-boating-and-transport/demerits-penalties-and-offences/how-demerit-points-work#:~:text=If%20you%20drive%20safely%20and,your%20licence%20can%20be%20suspended
[19] https://www.nsw.gov.au/sites/default/files/2022-11/Road-User-Handbook-English.pdf

Нийтээр амрах баярын өдрүүдэд болон сургуулийн бүс (*School Zone*)-т зөрчил гаргасан тохиолдол зөрчлийн оноог 2 дахин нэмж ногдуулах буюу, эсхүл үндсэн оноо дээр нэмэгдэл оноо ногдуулах журам үйлчилдэг байна.

Австралийн зөрчлийн онооны давуу болон сул тал

Давуу тал[20]

- *Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах*: зөрчлийн онооны системийн хамгийн гол давуу тал нь жолоочийн нийтэд аюултай зан үйлийг таслан зогсоох, сануулах, арилгах замаар замын хөдөлгөөний аюул, эрсдэлтэй байдлыг бууруулж буй явдал юм. Жолооч нар эрхийн үнэмлэхээ цуцлуулахгүйн тулд замын хөдөлгөөний дүрмээ илүү нягт баримтлах шаардлагатай болдог;

- *Хариуцлагатай жолоочийг хөхүүлэн дэмжих:* энэхүү систем нь жолооч нарын хариуцлага хүлээх мэдрэмжийг бий болгож, аюулгүй жолоодох дадал, зуршил сууж, жолоодлогын ур чадвараа нэмэгдүүлж, замын хөдөлгөөний дүрэм зөрчихөөс ямагт зайлсхийхэд тусалдаг;
- *Шийтгэлийн тодорхой бөгөөд ил тод байдал*: зөрчлийн онооны систем нь хариуцлагын тодорхой хүрээ, хязгаарыг бий болгож, жолооч нарт үйлдлийнхээ учир шалгаан, үр дагаврыг ойлгож ухамсарлахад илүү хялбар болгодог;

- *Жолооч нарт сайжрах, засрах боломжийг олгох*: жолооны үнэмлэхээ цуцлуулахын оронд цаашид замын хөдөлгөөнд биеэ зөв боловсон авч явах тодорхой үүрэг амлалт авсан тэнсэх хугацаа олгох, жолооны курст давтан сууж дадлагажих зэрэг алтернатив хувилбар санал болгон жолооч нарт алдаанаасаа суралцаж, жолоодлогын ур чадвараа дээшлүүлэх боломжийг олгодог байна.

Сул тал[21]

- *Улс орон даяарх жигд бус зохицуулалт*: муж, орон нутаг бүрийн онооны хуваарилалт, торгуулийн хэмжээ зэрэг ялгаатай зохицуулалт нь жолооч нарын дунд, ялангуяа хөдөө, орон нутгаар байнга зорчдог жолооч нарын хувьд төөрөгдөл, ойлгомжгүй байдал үүсгэдэг;

- *Шударга бус шийтгэл ногдуулах боломж*: систем нь заримдаа жижиг зөрчилд хатуу шийтгэл ногдуулах тохиолдол гардаг. Ялангуяа суралцагч (L) болон түр жолооч (P1, P2) зэрэг онооны хязгаар багатай жолооч нарт хатуу шийтгэл ногдуулдаг;

- *Захиргааны хүнд суртал, дарамт*: зөрчлийн онооны системийг удирдах, бүртгэлийн санг хөтлөх, шинэчлэх нь бүртгэлийг үнэн зөв, шуурхай хөтлөх, давж заалдах хүсэлтийг шийдвэрлэх зэрэгт ихээхэн захиргааны хүнд суртал, дарамтыг бий болгодог;

- *Эдийн засгийн үр дагавар*: зарим жолооч нарын хувьд жолоодох эрхээ цуцлуулсны эдийн засгийн үр дагавар нь тэнцвэргүй буюу харилцан адилгүй байж, амьжиргаа болон нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмжид сөргөөр нөлөөлдөг байна.

[20] *https://roadsense.org.au/complete-guide-demerit-points-in-nsw/*

[21] *https://migrationobservatory.ox.ac.uk/resources/reports/the-australian-points-based-system-what-is-it-and-what-would-its-impact-be-in-the-uk/*

2.2. ИБУИНХУ

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (Их Британи) нь үндсэн хуульт хаант засагтай парламентын ардчилсан улс юм. Төрийн тэргүүн нь III Чарльз хаан. Их Британи нь Англи, Шотланд, Вэльс, Умард Ирланд (Ирланд) гэсэн 4 улсаас бүрдэх бөгөөд эрх мэдлийн хүрээнд харьцангуй ялгаатай өөр өөрийн эрх мэдлийн засгийн газар, хууль тогтоох байгууллагатай юм.

Их Британийн нийт нутаг дэвсгэр дээр жолоочийн эрхийн онооны систем үйлчилдэг боловч замын хөдөлгөөний аюулгүй байдал нь улсуудын өөр өөрийн хууль дүрмээр нарийвчлан зохицуулагддаг байна. Их Британийн дээрх улсуудаас Ирландын жолоочийн зөрчлийн онооны системийг авч үзье.

Эрх зүйн орчин

Ирландын жолоочийн зөрчлийн онооны систем нь Их Британийнхаас тусдаа бөгөөд өөр хууль дүрэмтэй ч зохицуулалтын ерөнхий агуулга, зарчим хэрэглээ нь Англи, Вэльсийнхтэй төстэй бөгөөд дараах хууль тогтоомжоор зохицуулагддаг. Үүнд:

- Замын хөдөлгөөний тухай хууль[22] (Road Traffic Act (2002) тус хуулиар жолоочийн зөрчлийн оноо, жолоочид ногдуулах торгууль, зөрчлийн жагсаалтыг баталсан.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль[23] (Road Safety Act (2006) тус хуулиар зөрчилд хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон.
- Замын хөдөлгөөний зөрчлийн тухай (The Road Traffic Offenders 1996 Northern Ireland) зөрчил гаргачдаас оноо хасах мөн торгууль ногдуулахыг хамт хэрэглэх, зөрчлийн оноо нь гурван жилийн хугацаанд 12-оос дээш хүрсэн бол жолоодох эрх хасах зэрэг зохицуулалтыг шинээр тусгасан.

Ирландад жолоочийн зөрчлийн онооны системийг 2002 оноос бүрэн хэрэгжүүлэх болсон ба уг системд 2003 онд даатгал, хамгаалах бүс, болгоомжгүй жолоо барьсан зөрчилд оноо тооцохоор нэмсэн бол 2014 онд шинэ жолоочийн (learner) эрх хасах онооны босгыг тогтоосон байна.[24]

Зөрчлийн оноо

Жолоочийг тодорхой төрлийн зөрчил гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас түүнд ногдуулж буй торгуулийн оноог зөрчлийн оноо гэнэ. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар торгууль ногдуулдаг байна. Зөрчлийн оноо тооцох нь замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх, аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослыг бууруулах зорилготой.[25]

Жолоочийн үйлдсэн зөрчлийн хүнд хөнгөн, нийгмийн хор аюулын шинж чанараас шалтгаалж жолоочоос оноо хасах эсхүл тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэхийг шийдвэрлэдэг байна. Согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, аюултай аргаар жолоо барих зэрэг нь баривчлах шийтгэлтэй байдаг.

---

[22] *https://www.irishstatutebook.ie/eli/2002/act*

[23] *https://www.legislation.gov.uk/*

[24] *https://www.rsa.ie/*

[25] *https://www.citizensinformation.ie/en/travel-and-recreation/motoring/driving-offences/penalty-points-for-driving-offences/*

Дараах тохиолдолд зөрчлийн оноог жолоочийн бүртгэлд бүртгэнэ:

- Оноо хасаж торгууль ногдуулахаар заасан зөрчил үйлдсэн;
- Зөрчил үйлдсэн тухай мэдэгдэх хуудас авсан ба жолооч шүүхээр шийдвэрлүүлэхгүй торгууль төрөхөөр хүлээн зөвшөөрсөн.

Жолооч гурван жилд 12 зөрчлийн оноо хуримтлуулсан тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сарын хугацаагаар хасна. Жолоодох эрхээ хасуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор жолооны үнэмлэхээ Үндэсний жолооны лицензийн төвд хүлээлгэн өгөх үүрэгтэй. Ийнхүү өгөөгүй нь зөрчилд тооцогдох бөгөөд жолоодох эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох нь гэмт хэрэгт тооцогдоно. Замын цагдаа зөрчил гаргасан жолоочийг саатуулж торгуулийг хэмжээ, хасах оноог заасан мэдэгдэл шууд буюу шуудангаар дамжуулж өгөх ба жолооч мэдэгдлийг хүлээн зөвшөөрч төлөх эсхүл эс зөвшөөрч шүүхэд хандах эрхтэй. Зөрчилтэйд тооцох хугацаа 3 жил байх бөгөөд энэ нь Тээврийн газар дахь жолоочийн хувийн хэрэгт хадгалагддаг.

Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын алба (*Road Safety Authority-*[26]*RSA*) нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу байгуулагдсан Ирландын засгийн газрын харьяа агентлаг юм. Тус алба нь хүн бүрийн аюулгүй зорчих эрхийг хангах зорилготой. Энэ хүрээнд авто ослыг бууруулж хүний амь насыг аврах, иргэдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор цогц арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тус алба ‘’Оноо хасах, торгууль ногдуулах зөрчлийн жагсаалт’’-ыг 2022 онд баталсан.[27]

Оноо хасах, торгууль ногдуулах үйл ажиллагаа нь дараах гурван үе шаттай:

- Жолооч зөрчлийн мэдэгдэл авсан өдрөөс хойш 28 хоногт үндсэн дүнгээр торгууль төлнө;
- Хоёр дахь 28 хоногт торгууль төлбөл үндсэн торгуулийн үнийн дүн дээр 50 хувийг нэмж төлнө;
- Дээрх 56 хоногт багтааж торгууль төлөөгүй бол шүүхэд шилжинэ. Шүүх хурал болохоос 7 хоногийн өмнө торгууль төлж болох 3 дахь сонголт байна. Энэ үед анхны торгуулийн хэмжээнээс 2 дахин их торгууль төлөх ба хасагдах оноо мөн 2 дахин их байна.

Хүснэгт 2. Ирландын нийтлэг зөрчил ба тэдгээрийн оноо, торгуулийн хэмжээ

№	***Оноо хасах, торгууль ногдуулах зөрчил***	***Торгуулийн оноо***	***Торгуулийн хэмжээ €***		
			эхний 28 хоногт	***2 дахь 28 хоногт***	***3 дахь 28 хоногт***
1.	Гэмтэлтэй, хуучирсан дугуйтай тээврийн хэрэгсэл ашиглах	2	80	120	160
2.	Жолооны дамжааны суралцагч сургагч багшгүйгээр жолоо барих	2	160	240	320
3.	Буцаж эргэх замын тэмдэг зөрчих	2	60	90	120

[26] https://www.rsa.ie/
[27] https://www.rsa.ie/docs/default-source/services/s2-licensed-drivers/rsa-penalty-points-offences-2022.pdf?sfvrsn=7ef1d693_9

4.	Нэвтрэхийг хориглосон тэмдгээс цааш явах	1	60	90	120
5.	Хурд хязгаарлах төхөөрөмжөөр тоноглогдоогүй тээврийн хэрэгсэл жолоодох	3	120	180	240
6.	Тээврийн хэрэгсэл хооронд зай барихгүй зорчих	3	160	240	320
7.	School police-ийн тэмдэг зөрчих	2	160	240	320
8.	Тээврийн хэрэгсэл жолоодох үедээ гар утас ашиглах	3	120	180	240

Ирландын зөрчлийн онооны системийн давуу болон сул тал

Замын хөдөлгөөнд зөрчлийн онооны систем ашиглах нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослыг бууруулах зорилготой.[28] Зөрчил гаргасан жолооч нарт оноо тооцох нь аюултай зан үйл бүхий жолооч нарыг замын хөдөлгөөнд оролцохоос сэргийлэх, зөрчил давтан гаргахаас урьдчилан сэргийлдэг. Мөн зөрчлийн онооны системийг ашиглах нь зам тээврийн осол, хүний амь хохирох явдал 15-20 хувь бууруулсан тухай судлаачид дурджээ.[29] Тухайлбал, хориглосон гэрэл зөрчиж, уулзвар нэвтэрсэн жолооч автозамын камерт өртөн оноо хасуулсан бол дахин уг зөрчлийг гаргах магадлал бага байна. Тэрээр уулзвар нэвтрэх үедээ илүү сонор сэрэмжтэй байх ёстой. Хэрэв хуримтлагдсан оноог үл тоомсорлож дахин давтан зөрчил гаргасаар байвал жолоо барих эрхээ хасуулах хүртэл шийтгэлтэй[30] байдаг.

Харин торгууль ногдуулах гурван үе шат нь жолоочийг эдийн засгийн дарамтад оруулах, тэдний амьжиргааны нөхцөлийг харгалзаагүй зэрэг сул талтай байна.

2.3 ХОНКОНГ

Хонгконг нь БНХАУ-ын тусгай захиргааны хоёр бүсийн нэг бөгөөд нэгдмэл нэг нам, төрийн хүрээнд гүйцэтгэх засаглалтай. Харьяаллын хувьд 1942-1997 онд Хятадад шилжүүлэгдэх хүртлээ Нэгдсэн Вант Улсын захиргаанд байжээ. "Нэг улс, хоёр систем" гэсэн бодлогын дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн Газар нь Хонконгийн аюулгүй байдал, гадаад бодлогыг хариуцах тохиолдолд хуулийн систем, цагдаагийн хүчин, мөнгөн тэмдэгт, гаалийн бодлого цагаачлалын бодлого, олон улсын байгууллага, үйл явдалд илгээх төлөөлөгчдөө өөрөө зохицуулна. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд жолоочийн зан үйл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах зорилгоор жолоочийн онооны системийг ажиллуулдаг.

Жолоочийн зөрчлийн онооны зорилго нь: замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ бөгөөд зөрчил хэргийг таслан зогсоох, ослын тоог бууруулах, жолооны стандартыг сайжруулах явдал юм.

Жолоодох эрхийн оноо буюу жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо нь зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, учрах хохирлыг багасгах, жолооч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлж, замын хөдөлгөөнд соёлтой оролцуулахад чиглэдэг зүйл. Өөрөөр

[28] https://www.ndls.ie/help/faq.html#what-are-penalty-points
[29] https://www.sciencedirect.com/science/article/
[30] https://www.brindley.co.uk/news/penalty-points-on-your-uk-driving-licence-explained/

хэлбэл, жолооч нарыг илүү хариуцлагатай байхад чиглэж, зөрчил гаргах бүрд нь жолоодох эрхийн оноотой нь хариуцлага тооцдог онооны систем юм.

Эрх зүйн орчин

Жолоодох эрхийн онооны систем нь “Замын хөдөлгөөний хууль”, “Эрүүгийн хууль”-иар зохицуулагдаг. Жолооны зөрчлийн онооны системийг 1984 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс батлан мөрдөж эхэлсэн бөгөөд дараах тохиолдолд жолооны зөрчлийн оноог тооцно.

(а) жолооч шүүхээр шийтгэгдсэн;

(б) жолооч торгуулсан.

Жолоочийн зөрчлийн оноонд: замын хөдөлгөөний бүх зөрчлийг хамруулахгүй бөгөөд зөвхөн замын хөдөлгөөний аюулгүй байдалд шууд хамааралтай зөрчлүүдийг тооцдог байна. Үүнд: нийтдээ 50 гаруй зөрчлийг хамруулжээ.

“Замын хөдөлгөөний тухай хууль”-ийн[31] 375 дугаар бүлэгт “Жолоочийн зөрчлийн оноо” тухай заасан байдаг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор жолооны курст заавал хамрагдсан байх, оноог бүртгэх, олон төрлийн зөрчил гаргасан, жолоодох эрхээ хасуулсан, тодорхой тооны оноо авсан, жолоодох эрхээ дээшлүүлэх зэрэг асуудлуудыг зохицуулан Замын хөдөлгөөний дүрэм (*Жолооны зөрчлийн оноо*)-ийг батлан мөрдүүлдэг. (*1984 оны наймдугаар сарын 25 1984 оны LN 295, 2008 оны 23 дугаар зүйлийн 58 нэмэлт өөрчлөлт оруулсан*). Энэхүү онооны систем нь тодорхой хязгаарт хүрсэн тохиолдолд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуулийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авна. Мөн ял шийтгэлийн эсрэг давж заалдах эрх нь хууль эрх зүйн хүрээнд нээлттэй байна.

Зөрчлийн онооны систем нь: замын хөдөлгөөний зөрчилд шийтгэлээс гадна “Жолоочийн зөрчлийн оноо”-г тооцдог. Тодорхой тооны оноо авсан тохиолдолд торгууль төлөх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах хүртэл арга хэмжээ авна.

Зөрчлийн оноо: Жолоодох эрхийн үнэмлэх бүхий этгээд, зам тээврийн зөрчил гаргасан тохиолдолд түүнд ногдуулах торгуулийн оноог “Жолоочийн зөрчлийн оноо“ гэнэ. Жолоодох эрхийн үнэмлэх авсан жолооч 0 онооноос эхлэх бөгөөд тухайн жолооч ямар ч аюул, эрсдэл гаргалгүйгээр жолоо барьсан, ямар нэгэн зөрчил гаргаагүй бол түүний оноо 0 хэвээр байна.

Хэрэв жолооч автомашин жолоодож байхдаа эсхүл мотоцикл унаж байхдаа зөрчил гаргасан бол тухайн жолоочийн бүртгэлд зөрчлийн оноо нэмэгдэн тооцогдох зарчмаар дүгнэдэг. Зөрчилд оноо тооцохоос гадна давхар торгууль ногдуулдаг, зөрчил гэмт хэргийн шинжтэй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Мөн зөрчлийн онооны дээд хязгаарт хүрвэл Авто тээврийн газраас жолоодох эрхийг түдгэлзүүлсэн, цуцалсан тухай, эсхүл жолоочийн үнэмлэх авах хүсэлт гаргасан бол татгалзсан тухай мэдэгдэл илгээдэг байна. Тус мэдэгдэлд түдгэлзүүлэх, цуцлах, эсхүл татгалзах хугацаа эхлэх огноог заавал тусгана.

Нийтлэг зөрчил ба тэдгээрийн оноог зөрчлийн хөнгөн, дунд зэрэг, хүнд гэсэн 3 төрлөөс хамааран 3,5,10 гэсэн оноо өгдөг байна.

---

[31] https://www-hklii-hk *Замын хөдөлгөөний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай*

Хүснэгт 3. Хонконгийн нийтлэг зөрчил болон тэдгээрийн оноо

Оноо	***Нийтлэг зөрчил***
10 оноо	Аюултай жолоодлого хийсэн, түүний улмаас хүнд гэмтэл учруулсан болон амь нас хохироосон тохиолдолд;
	Согтууруулах унаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үед тээврийн хэрэгсэл жолоодсон буюу жолоодохыг оролдсон тохиолдолд;
	Согтуу гэж сэжиглэсэн тохиолдолд амьсгалын сорьц, цус, шээсний шинжилгээ өгөхгүй байх, зөвшөөрөхгүй байх;
	Хурдны дээд хязгаарааас илүү хурдтай жолоодсон тохиолдолд; (45км,70км гэх мэт)
5 оноо	Болгоомжгүй жолоодсон тохиолдолд;
	Ослын дараа зогсохгүй байх үед;
	Хурдны хязгаар 30 км-ээс дээш хурд хэтрүүлэн жолоодсон;
3 оноо	Ослын дараа зогсохгүй, мэдээлэл өгөхгүй байх тохиолдолд;
	Замын голын тасралтгүй давхар шугам дээгүүр гатласан үед;
	Эрх бүхий албан тушаалтны заавар, дохиог дагаж мөрдөхгүй байх үед;
	Явган зорчигчид гарц дээр давуу эрх олгохгүй байх тохиолдолд;
	Хурдны дээд хязгаар (15-30 км г.м)-ыг хэтрүүлсэн тохиолдол.

Онооны бүртгэл: уг асуудлыг эрхэлсэн эрх бүхий ажилтан системд бүртгэх ба оноог тухайн иргэний нэр дээр гаргасан зөрчил, зөрчил үйлдсэн огноо зэрэг бусад мэдээллийг нарийн тодорхой бүртгэнэ.

Онооны бүртгэл хөтлөлт: зөрчил тус бүрд ноогдуулсан зохих оноог бүртгэж хөтөлнө. Торгууль шийтгэлийг ноогдуулах, тодорхой тохиолдолд цуцлах, хариуцлагыг сэргээх зэрэг харилцааг зохицуулсан. Үүнд:

- торгуулийн хариуцлагыг эрх бүхий этгээд хүчингүй болгосон, шүүгч хүчингүй болгосон, буцааж цуцалсан тодорхой тохиолдолд зөрчлийн оноог хүчингүй болгож болно;
- үйлдсэн зөрчил, хэргийг сэргээсэн, дээд шатны шүүх торгууль төлөх шийдвэр гаргасан тохиолдолд зөрчлийн оноог сэргээнэ.

Торгуулийн оноог давж заалдаж болох бөгөөд хүний амь насыг санаатай хөнөөсөн ялын эсрэг давж заалдах гомдлыг хүлээн авсан, өөр зөрчилд хамруулах шийдвэр гарсан үед онооны бүртгэлийг хүчингүй болно.

Оноо цуцлах: дараах 2 хүчин зүйлээс шалтгаалан цуцална**.** Үүнд:

- зөрчлийн онооны дээд хязгаарт хүрснээс жолооны үнэмлэх эзэмших эрхээ хасуулсан, зөрчил хэрэгт ял шийтгүүлсэн бол оноо цуцлагдана;
- жолоодох эрхээ алдсаны дараа дахин сургалтад хамрагдах болсон тохиолдолд хуримтлуулсан оноог цуцална.

Онооны мэдэгдэл: Зөрчлийн оноо 8-15 хүрсэн үед мэдэгдэл өгнө.

Эрх хасах: журамд зааснаар 2 жилийн хугацаанд 15 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг хасна. Мөн замын хөдөлгөөний зөрчлийн хохирлын шинжээс хамаарч бусад холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэх бөгөөд хяналтын системд бүртгэж авна.

Баталгаа: тогтоосон гэмт хэрэг, зөрчлийн улмаас ял шийтгүүлсэн эсхүл тодорхой шийтгэл оногдуулсан, торгууль ногдуулсан тохиолдолд түүнийг батлах ба нотлох баримт үйлдэнэ.

Жолооны үнэмлэх хураалгах: эрх хасах шийдвэр гарснаас хойш 72 цагийн дотор холбогдох захиргааны эрх бүхий этгээдэд үнэмлэхээ хураалгана.

Үнэмлэх хураах, мэдэгдэл хүргүүлэх: жолоодох эрхийг хасах шийдвэр гарсан талаар комиссар болон Замын цагдаагийн комиссарт нэн даруй мэдэгдэх ёстой бөгөөд жолооны үнэмлэхийг хураах өдрийг мэдэгдэнэ.

Жолоодох эрх болон үнэмлэх: жолоодох эрхээ хасуулсан жолоочийн олон улсын болон дотоодын жолооны үнэмлэхийг хураан авч, Комиссарт шилжүүлж, тэмдэглэл үйлдэж эрхээ хасуулсан тухай жолооны үнэмлэх олгосон байгууллагад мэдэгдэнэ.

Зөрчил ба торгууль: Хонконгийн жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо болон торгуулийн хэмжээ нь зөрчлийн ноцтой байдал, төрлөөс хамааран өөр өөр байдаг. Жишээлбэл:

- *Хөнгөн зөрчил (1 дүгээр түвшин*) 3-5 оноо авахад торгуулийн хэмжээ нь ойролцоогоор 320-450 Хонконг доллар байна. (хурд тохируулалгүй явах, замын тэмдэглэгээг зөрчих, хамгаалалтын бүс хэрэглэхгүй байх г.м)

- *Дунд зэргийн зөрчил (2 дугаар түвшин)* 6-8 оноо авахад торгуулийн хэмжээ нь 600-1000 Хонконг доллар байна. (улаан гэрлээр явах, зөвшөөрөгдсөн хурдыг 30%-аас дээш хэтрүүлэх зэрэг)

- *Хүнд зөрчил (3 дугаар түвшин*) 10-15 оноо авахад торгуулийн хэмжээ нь 1500-5000 Хонконг доллар буюу түүнээс дээш байна. (согтуугаар жолоо барих, жолоодох эрхийг түдгэлзүүлсэн үед жолоо барих г.м)

***Бүртгэлийн залруулга*:** жолоочийн зөрчлийн оноог бүртгэлд буруу оруулсан тохиолдолд мэдээллийн бүртгэлийг залруулах хүсэлтийг комисст гаргаж болно. Хэрэв жолоочийн оноог бүртгэлд буруу оруулсан гэж үзэж байгаа бол цагдаагийн комиссартай зөвшилцсөний дараа бүртгэлийг засаж, тухайн хүнд бичгээр мэдэгдэнэ.

Мэдэгдлийн үйлчилгээ: энэхүү мэдэгдлийг түүнд өөрийн биеэр буюу Замын хөдөлгөөний дүрмийн дагуу комисс нь жолооны үнэмлэхийн бүртгэлд заасан хаяг буюу шуудангаар мэдэгдлийг илгээнэ.

Жолоочийн зөрчлийн оноог тооцохдоо[32] жолоочийн үйлдсэн зөрчлийг тооцох бөгөөд (*Замын хөдөлгөөний дүрэм 375 дугаар бүлэгт дурдсан зөрчил*) гэм буруутайд тооцсон тохиолдолд торгууль ногдуулна.

Хэрэв 8 оноо авсан бол: түүнээс дээш 15-аас доош оноо авсан тохиолдолд Авто тээврийн газраас жолоочийн зөрчлийн онооны талаар зөвлөгөө өгнө. Энэхүү зөвлөгөө нь 2 жилийн хугацаанд үйлдэгдсэн жолоочийн зөрчлийн онооны талаар дэлгэрэнгүй мэдээлэх бөгөөд илүү олон оноо хуримтлагдвал үүсэх үр дагаврын талаар сануулна. Энэ нь жолооч замын

[32] *https://www.gov.hk/ Зөрчлийн оноог тооцох*

хөдөлгөөнд оролцохдоо аюулгүй байдлыг анхаарах, авар ослоос урьдчилан сэргийлэн сэрэмжлүүлэх зорилготой юм.

Хэрэв та 10 оноо авсан бол: 2 жилийн хугацаанд гаргасан зөрчил нь 10 ба түүнээс дээш оноонд хүрсэн тохиолдолд Авто тээврийн газраас жолооны курст заавал хамрагдах тухай мэдэгдлийг өгнө. Энэхүү мэдэгдэл гарсан өдрөөс хойш 3 сарын дотор өөрийн зардлаар жолооны курст дахин сургалтад хамрагдаж төгсөх ёстой.

Хэрэв та 15 оноо авсан бол: 2 жилийн хугацаанд үйлдсэн зөрчил нь 15 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд жолоодох эрхийг шүүхээс хасна. Жолоодох эрхээ анх удаа хасуулж байгаа тохиолдолд 3 сарын хугацаатай байх бөгөөд давтан үйлдсэн бол энэ хугацааг 6 сар хүртэл нэмэгдүүлнэ.

Зарлан дуудах хуудас: жолоочийн гаргасан зөрчил нь 2 жилийн хугацаанд 15 ба түүнээс дээш оноонд хүрсэн тохиолдолд зарлан дуудах хуудсыг Авто тээврийн газрын бүртгэлтэй хаяг (шуудангаар) хүргүүлнэ. Хэрэв шүүх хуралд ирээгүй тохиолдолд зарлан дуудах хуудсыг бүртгэлтэй хаяг (шуудангаар) дахин хүргүүлнэ. Авто тээврийн газрын бүртгэлтэй хаягаар (шуудан) зарлан дуудах хуудас хүргүүлсэн ч аваагүй, буцаагдсан тохиолдолд зарлан дуудах хуудсыг хүлээн авсанд тооцогдоно.

Шүүх хуралд ирээгүй тохиолдолд: Хэрэв зарлан дуудах хуудас ирсэн эсхүл хүлэн авсан гэж үзвэл заасан газар, цагт хүрэлцэн ирээгүй охиолдолд шүүхээс баривчлах шийдвэр гаргаж, Авто тээврийн газраас жолоодох эрх олгох болон давтан эрх дахин олгох, сунгахаас татгалзана.

Жолооны сургалт болон онооны цахим бүртгэл: Жолооны сургалтыг хангалттай төгссөн тохиолдолд жолоодох эрхийн гэрчилгээ олгоно. Жолоочийн зөрчлийн онооны бүртгэлийг Цагдаагийн газар, Замын хөдөлгөөний зөрчлийн бүртгэлийн албанд бүртгэн цахим системд бүртгэсэн байна.[33]

Жолоочийн зөрчлийн бүртгэлийн онооны давуу болон сул тал

Давуу тал[34]

- Замын хөдөлгөөний зөрчил 30%-иар буурч, жолоодох ур чадвар сайжирсан.
- Осолд өртсөн эмчлүүлэгчдийн тоо 50%-иар буурсан.
- Осол, нас, баралт, гэмтлийг 15-20 % бууруулахад хамгийн их нөлөө үзүүлсэн;
- Жолооч нарыг замын хөдөлгөөнд тэгш байдалтай оролцох боломжийг бүрдүүлдэг.

Сул тал

- Оноо тооцож эхэлснээс хойш жолооч болон холбогдох эрх бүхий этгээдүүдийн хооронд зөрчилтэй байдал үүсдэг байна.

----------oOo----------

[33] https://www.police.gov.hk/ppp_en/05_traffic_matters/tcr.html
[34] https://www-sciencedirect-com *Онооны системд суурилсан жолооны үнэмлэх*

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Ерөнхий мэдээлэл

- Drective of the European Parliament and of the Council https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A52023PC0127
- Quantitative Analysis of the Social Costs of Road Traffic Crashes Literature https://www.sciencedirect.com/science/article/abs/pii/S0001457521003134
- https://www.quora.com/Do-other-countries-use-a-points-system-on-their-driving-license-laws

Австралийн Холбооны Улс

- Road User Handbook: Transport for NSW: https://www.nsw.gov.au/sites/default/files/2022-11/Road-User-Handbook-English.pdf
- https://www.nsw.gov.au/driving-boating-and-transport/demerits-penalties-and-offences/how-demerit-points-work#:~:text=If%20you%20drive%20safely%20and,your%20licence%20can%20be%20suspended
- https://www.transport.wa.gov.au/licensing/demerit-points.asp
- https://legislation.nsw.gov.au
- https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/act-2013-018
- https://legislation.nsw.gov.au/view/html/inforce/current/sl-2017-0450

ИБУИНХУ

- Driver accident risk in relation to the penalty point system in British Columbia https://www.gov.uk/penalty-points-endorsements/
- https://www.rsa.ie/services/licensed-drivers/penalty-points/
- https://www.citizensinformation.ie/en/travel-and-recreation/motoring/driving-offences/penalty-points-for-driving-offences/
- https://www.garda.ie/
- https://www.ndls.ie/help/faq.html#what-are-penalty-points
- Policy for Prosecuting Road Traffic Offences https://www.ppsni.gov.uk/
- Driving licenses based on points systems: Efficient road safety strategy or latest fashion in global transport policy? A worldwide meta-analysis

Хонконг

- Замын хөдөлгөөний тухай хууль https://www-hklii-hk
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай
- Зөрчлийн оноо тооцох журам https://www.elegislation.gov.hk
- Зөрчлийн оноог тооцох https://www.gov.hk/
- https://www.police.gov.hk/ppp_en/05_traffic_matters/tcr.html
- Онооны системд суурилсан жолооны үнэмлэх https://www-sciencedirect-com